

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ХҮҮЛИЙН МЭРГЭЖИЛТЭН Ө.НАРМАНДАХЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт			Гүйцэтгэлийн түвшин				
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
НЭГ. “Байгууллагын хэмжээнд төрийн албаны тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Арга хэмжээ 1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд чиг үүргийн дагуу санал өгөх, хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	94%	100%-аас доошгүй	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/141 дугаар тушаалаар “Нийгмийн байгуулагдсан даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр томилогдсон. Эхний хагас жилийн байдлаар А/199 дүгээр тушаалаар батлагдсан журамд өөрчлөлт оруулах саналыг 1 удаа хүргүүлсэн.	2025.01.02 2025.06.15	
2.	Арга хэмжээ 2. Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланг боловсруулах, батлуулах, хүргүүлэх	Тухай бүр	2 удаа	100%-аас доошгүй	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа тогтоол шийдвэрийн биелэлтүүдийг заалт бүрээр нэгтгэн гаргаж НДЕГ-т хүргүүлэхэд бэлэн болгосон.	2025.01.02 2025.06.15	

3	Арга хэмжээ 4. Монгол Улсын Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрэм, газрын дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих, хангуулах	Тухай бүр	100%	100%-аас доошгүй	Тус газрын ажилтан, албан хаагчид, мэргэжилтнүүдийн ажиллагаатай холбоотой газрын даргын тушаал, эрх зүйн актын хэрэгжилтэд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрэм, газрын дотоод журмыг хэрхэн үндэслэж байгаад тогтмол хяналт тавьж, шийдвэрийг гарган ажиллалаа.	2025.01.02 2025.06.15	
4	Арга хэмжээ 4. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" болон "Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулах	Тухай бүр	100%	100%-аас доошгүй	Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" болон "Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтийг газрын хэмжээнд хангуулах ажилд газрын ёс зүйн дэд хорооны гишүүд болон хэлтсийн дарга нарын хамт тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 1 байцаагч, мэргэжилтэнд холбогдуулан гаргасан өргөдлийг хүлээн авч холбогдох шалгалтыг явуулж, дүгнэлтийг гаргаж танилцуулсан.	2025.01.02 2025.06.15	
Хоёр. "Захиргааны акт, гэрээ, эрх зүйн баримт бичгийн үндэслэлийг хянах, мэргэшлийн зөвлөгөө, мэдээллээр хангах, хяналт тавих, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх асуудалд байгууллагаа төлөөлөн оролцох" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 1. Захиргааны акт, гэрээ, эрх зүйн баримт бичгийн үндэслэлийг хянах	Тухай бүр	5	100%-аас доошгүй	Газрын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжтэй ажил гүйцэтгүүлэх чиглэлээр байгуулсан 1 гэрээ, А тушаал 10, Б тушаал 50-г тус тус хууль эрх зүйн талаас нь хянаж, зөвлөгөө өгч ажиллалаа.	2025.01.02 2025.06.15	

2	Арга хэмжээ 2. Байгууллагын удирдлага, албан хаагчид болон иргэн, хуулийн этгээдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх	Тухай бүр	250 иргэн, 40 аж ахуйн нэгжид хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан	100%-аас доошгүй	Тайлангийн хугацаанд газрын дарга болон хэлтсийн дарга нарт хууль эрх зүй, хүний нөөцийн талаар давхардсан байдлаар 13 удаа зөвлөгөө мэдээлэл, иргэн, аж ахуйн нэгжид 33 удаа хууль эрх зүйн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.	2025.01.02 2025.06.15	
3	Арга хэмжээ 3. Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх асуудлаар газрыг төлөөлөн оролцох, хамтран ажиллах	Тухай бүр	Иргэний 44, захиргааны 5 хэрэг маргаан д газрыг төлөөлөн оролцсон	100%-аас доошгүй	Тус газрын нэхэмжлэлтэй болон хариуцагчаар татагдсан иргэний болон захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны шүүхийн хэрэг маргаанд 2025 оны эхний хагас жилийн байдлаар газрын даргын итгэмжлэлээр 18 хэрэг маргаанд оролцсон байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу 1 эрүүгийн хэрэгт хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон оролцсон байна.	2025.01.02 2025.06.15	
4	Арга хэмжээ 4. Хууль хяналтын байгууллагад нэхэмжлэл, хариу тайлбар, хүсэлт, мэдээллийг хянах, боловсруулах, удирдлагаар хянуулж хүргүүлэх	Тухай бүр	52 удаа нэхэмжлэл гаргаж холбогдох шүүхийн байгууллагад шилжүүлсэн.	100%-аас доошгүй	Нийгмийн даатгалын шимтгэлээ тогтоосон хугацаанд төлөөгүй, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн 16 аж ахуйн нэгжид холбогдуулж 2 020 431490.39 төгрөгийг гаргуулах нэхэмжлэлийг холбогдох шүүхийн байгууллагад гаргасан байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж тус газрыг хариуцагчаар татсан 1 захиргааны хэрэг, иргэний хэргийн анхан шатны	2025.01.02 2025.06.15	

						шүүхэд 1 хэрэг маргаанд үндэслэл бүхий хариу тайлбарыг гаргаж хүргүүлсэн байна.		
ДӨРӨВ. “Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1	Арга хэмжээ 1. Үйл ажиллагааны болон Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, ажлын үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлүүлэх, тайлагнах	Ажлын төлөвлөгөө 1 удаа, биелэлт 2 удаа	100%	100%-аас доошгүй	Үйл ажиллагааны болон Төрийн жинхэнэ албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн ажлын үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлүүлэхээр бичмэл тайлан болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хуудсыг хэлтсийн даргад хүргүүлээд байна.	2025.01.02 2025.06.15		
2	Арга хэмжээ 2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох дүрэм, журмыг мөрдлөгө болгон ажиллах	Тухай бүр	100%	100%-аас доошгүй	Тайлангийн хугацаанд төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох дүрэм, журмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажилласанаар 2025 оны эхний хагас жилийн байдлаар ёс зүйн ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллалаа.	2025.01.02 2025.06.15		
3	Арга хэмжээ 3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх, биелэлтийг хангах, тайлагнах	Тухай бүр	100%	100%-аас доошгүй	Газар хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь хэрэгжүүлэн ажиллаж, биелэлт үр дүнг тогтмол танилцуулан ажиллалаа.	2025.01.02 2025.06.15		
4	Арга хэмжээ 4. Өргөдөл, гомдол, санал, албан бичигт хариу өгөх	Тухай бүр	Ёс зүйн дэд хороонд хандаж гаргасан н 1 иргэний өргөдөл	100%-аас доошгүй	Ёс зүйн дэд хороонд хандан иргэнээс гаргасан өргөдлийг хүлээн авч шалган, хуулийн хугацаанд нь иргэнд хариу өгч ажилласан.	2025.01.02 2025.06.15		

			йг шийдвэрлэсэн						
5	Арга хэмжээ 5. Ажлын чиг үүрэгтэй холбоотой судалгаа, мэдээ, тайлан гаргах	Тухай бүр	100%	100%-аас доошгүй	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид холбогдуулан нэхэмжлэл гаргаж шүүхэд хүргүүлсэн, шүүхийн шийдвэрийг биелүүлээгүйгээс Банкны төлбөр барагдуулах газарт хүргүүлсэн, тодорхой оршин суух хаягандаа байхгүй аж ахуйн нэгжүүдийн талаарх судалгааг гаргаж НДЕГ-ын ШХУАЗГ-н мэргэжилтэнгүүдэд 2 удаа хүргүүлээд байна.	2025.01.02 2025.06.15			
6	Арга хэмжээ 6. Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллах	Тухай бүр	100%	100%-аас доошгүй	Дээд газар болон бусад газарт хүргүүлж байгаа албан бичиг, харьяалах шүүхэд гаргаж байгаа нэхэмжлэл, хариу тайлбаруудыг гаргахдаа албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартын дагуу гаргаж хэвшээд байна.	2025.01.02 2025.06.15			
7	Арга хэмжээ 7. Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэн өгөх	Тухай бүр	100%	100%-аас доошгүй	Хуулийн мэргэжилтний 2024 онд зохион байгуулсан ажил, арга хэмжээ, иргэний болон захиргааны хэргийн шүүх хурлын материалуудыг нэгтгэж, зохих зааврын дагуу хөтөлж, архивын нэгж үүсгэхэд бэлэн болгоод байна.	2025.01.02 2025.06.15			
8	Арга хэмжээ 8. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах, ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд нь гаргах	Тухай бүр	100%	100%-аас доошгүй	Тайлангийн хугацаанд шүүх хуралдаан болон бусад үйл ажиллагаанд оролцохдоо ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажилласан.	2025.01.02 2025.06.15			

						2024 оны ХАСХОМ-г хуулийн хугацаанд гаргах мэдүүлсэн.		
9	Арга хэмжээ 9. Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүрэг хүлээх	Тухай бүр	100%	100%-аас доошгүй		Тус газрын хэмжээнд бүртгэлтэй байгаа аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээ, мэдээллийн нууцлалыг хуульд заасны дагуу бусдад задруулахгүй, бусдад мэдээлэхгүй ажиллалаа.	2025.01.02 2025.06.15	
10	Арга хэмжээ 10. Олон нийтийн арга хэмжээнд оролцох, зохион байгуулах	Тухай бүр	100%	100%-аас доошгүй		Газраас болон нийслэлийн Нийгмийн даатгалын газруудын дунд зохион байгуулагдсан спортын олон төрөлт тэмцээний "Ширээний теннис-ний төрөлд оролцож, 2-р байр эзэлж, өргөмжлөл, мөнгөн медалиар шагнагдсан.	2025.01.02 2025.06.15	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (Арга хэмжээ №1) Ажлын бүтээмжийг дээшлүүлж нийтийг хамарсан ажилд бүрэн, идэвхтэй оролцоно.	Нийтийг хамарсан ажилд бүрэн, идэвхтэй оролцох	-	100%	БГД ЗДТГ-с зохион байгуулсан харьяа хэлтэс албадуудын дунд 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 02 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан 5 төрөлт тэмцээнд Волейболийн төрөлд амжилттай оролцож гутгаар байр эзэлсэн. 2025 оны 04 дугаар сарын 30-ны өдөр Сонгино-хайрхан дүүргийн НДГазраас зохион байгуулсан "Ширээний теннис"-н тэмцээнд оролцож дэд байр эзэлсэн. 2025 оны 04 дүгээр сард Бүх нийтээр "Мод тарих өдөр" 57 дугаар цэцэрлэгийн хашаанд ногоон төгөлд мод тарьсан.	2025.01.02 2025.06.15	

					2025 оны 03 дугаар сард Нийслэлийн 9н дүүргийн дунд "Шатар"-н аврага шалгаруулах тэмцээн, Байгууллага хамт олны дунд 05 дугаар сард "Ширээний теннис"-ны тэмцээн Спорт хамтлагийн гишүүдтэй хамтран зохион байгуулсан. 2025 оны 06 дугаар сарын 01-ны "Хүүхдийн эрхийг хамгаалах" өдөр БГД-н 2, 19 хороодын Ажлын албаныхантай хамтран тус хороодын хүүхдүүдийн дунд 13-15,16-18 насны ангилалд 3vs3 сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан.				
2.	Арга хэмжээ №2. Ажлын тайлан мэдээ гаргаж хүргүүлэх	Тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргүүлэх	-	100%		Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/105 дугаартай тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын ерөнхий газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө"-ний биелэлтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж НДЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн.	2025.01.02 2025.06.15		

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Гүйцэтгэлийн түвшин								
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			3	4				
1	Арга хэмжээ 2. Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-ийн хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн	Тухай бүр		100%	Баянгол дүүргийн Насан туршийн боловсролын төвөөс тус газрын ажилтан, албан хаагч нарт зориулж явуулсан Монгол			

	явуулахад бэлтгэгдсэн байх тул тус бичгээр бичиж сурсан байх, албан хэргээ хөтлөх чадвартай болсон байх				бичгийн анхан шатны 4 цагийн сургалтанд хамрагдсан.		
2	Арга хэмжээ 5. Хиймэл оюун ухаанд суурилсан хэрэглээний сургалтанд хамрагдсан байх	Тухай бүр	100%		“ДИЖИТАЛ ШИЙДЭЛ БА ХИЙМЭЛ ОЮУНЫ ХӨГЖЛИЙН ТӨВ”-өөс зохион байгуулсан хиймэл оюун ухааны үндсэн ойлголтыг танилцуулах, албан хэрэгцээнд хиймэл оюун ухааныг ашиглан ажлын бүтээмжийг хэрхэн нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад ойлгомжтой хурдан шуурхай хүргэж түгээн дэлгэрүүлэхэд “AI” /Хиймэл оюун ухаан/-ыг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар мэдлэг олгох, үр чадварыг дээшлүүлэх лекц, хэлэлцүүлэг, харьцуулалт хийх семинарын ажил гэсэн нийт 5 цагийн багц сургалтанд хамрагдан гэрчилгээ авсан байна.		

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

..... /Ө.НАРМАНДАХ /
(Хэрэгчийн үсэг)

.....
(Огноо)